

СЭТГҮҮҮЛЧИЙН НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙГ ХАМГААЛАХ НЬ

Др. Ч.Базар

НУУЦ ЭХ СУРВАЛЖ ГЭЖ ХЭН БЭ?

Олон нийт, улс орны эрх ашигт
хохирол учруулахуйц үнэ цэнэ
бүхий мэдээллийг ил гаргасан
эх сурвалж

НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙГ ХЭН, ЯАГААД ХАМГААЛАХ ЁСТОЙ ВЭ?

Олон нийт, улс орны эрх ашигт хохирол учруулахуйц үнэ цэнэ бүхий мэдээллийг ил гаргасан эх сурвалжийн ажил, аюулгүй байдал, гэр бүлийг эрсдлээс сэргийлж **СЭТГҮҮЛЧ, ХМБ** тухайн эх сурвалжтай холбоотой **НЭР, АЖИЛ, АЛБАН ТУШААЛ** зэрэг мэдээллийг зориудаар нууцалдаг. Энэ бол эх сурвалжаа эрсдлээс сэргийлсэн **ХАМГААЛАЛТ**.

ЯАГААД

НУУЦ ЭХ СУРВАЛЖ ХАМГААЛАЛТ ХҮСДЭГ ВЭ?

Ихэнх тохиолдолд нууц мэдээллийг тээгч нь сэтгүүлчдийг өөрөө эрж олдог нэг ёсондоо **СЭТГҮҮЛЧИД ИТГЭЛ** үзүүлдэг.

Нууц мэдээллийг задруулснаараа хууль дүрэм, тухайн байгууллагатай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээ зөрчиж шийтгэл хүлээх эрсдэлд ордог учир **ХАМГААЛАЛТ** буюу **НЭРЭЭ НУУЦЛАХЫГ** хүсдэг. Хамгийн гол зүйл нь тухайн эх сурвалжид **ОЛОН НИЙТ, УЛС ЭХ ОРНЫ ЭРХ АШИГТ ХОХИРОЛ УЧРУУЛАХУЙЦ ҮНЭ ЦЭНЭ БҮХИЙ МЭДЭЭЛЭЛ** бий гэдэгт та бүхэн анхаарлаа хандуулаарай.

ИЙМ ТОХИОЛДОЛД СЭТГҮҮЛЧ, ХМБ ЯМАР ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХ ВЭ?

- ◎ Нэг талаас сэтгүүлч мэргэжлийн ёс зүйн зарчмийн үүднээс мэдээллийн эх сурвалжаа нууцлах, илчлэхээс татгалзах ёс зүйн үүрэг хүлээнэ.
- ◎ Нөгөө талаас эх сурвалжаа нууцалж чадсанаар бусад хамаарал бүхий эх сурвалжаас мэдээлэл авах боломжтой болно.
- ◎ Үүнийг СЭТГҮҮЛЧ + ЭХ СУРВАЛЖ = ИТГЭЛЦЛИЙН ХАРИЛЦАА гэж нэрлэж болно.

НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙГ ХАМГААЛАХ

Сэтгүүлч, эх сурвалжийн хооронд тогтсон илтгэлцлийн харилцааг эрх зүйн хүрээнд хамгаалах асуудал сүүлийн 20 гаруй жил дэлхийн улс орнуудад ихээхэн хүчтэй яригдаж байна.

Шалтгаан нь:

- ◎ Хүний үзэл бодлоо илэрхийлэх язгуур эрх, эрх чөлөөг хамгаалах
- ◎ Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах
- ◎ ХМХ-ээр дамжуулан төрд тавих олон нийтийн хяналтыг хүчтэй болгох
- ◎ Эцэстээ ардчилал, ардчилсан засаглалыг мөн чанараар нь хөгжүүлэх

НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙГ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ХАМГААЛАХ НЬ

Нууц эх сурвалжийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг дэлхийн 100 орчим улсад мөрдөж байгаа бөгөөд тэдгээрээс 20 орчим нь Үндсэн хуулиараа /Испани, Португал/, үлдсэн хэсэг нь хэвлэлийн хууль /Швед, Австри/, Эрүүгийн болон Иргэний процессын хуульд /Франц, Перу/ тусгайлан заалтууд оруулж баталгаажуулсан байна. Бельги зэрэг оронд “Эх сурвалжаа хамгаалах тухай” бие даасан хуультай байна.

НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙГ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД ХАМГААЛАХ НЬ

Европын конвенцийн дагуу Европын шүүхийн жишиг, улс орнуудын сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн хэм хэмжээгээр мөн зохицуулдаг. Европын Хүний эрхийн шүүх нь нууц эх сурвалж бол “хэвлэлийн эрх чөлөөний нэг үндсэн нөхцөл” бөгөөд түүнд халдах нь буруу үйлдлийг өөгшүүлэх “цэвдэг хүйтэн зүйл” хэмээн үзэж, эх сурвалжийг хамгаалах асуудалд хатуу тууштай байдаг.

НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙН ХАМГААЛАЛТЫН ТҮВШИН

◎ Үнэмлэхүй буюу туйлын хамгаалалт :

Эх сурвалжаа хамгаалах нь ямар ч эрх ашгаар хязгаарлагдахгүй гэсэн ойлголт. “Мэргэжлийн нууцын эх сурвалж үнэмлэхүй байдлаар хамгаалагдсан байх бөгөөд түүнийг задруулахыг хэн ч шаардах эрхгүй. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон шүүх хурлын явцад нууц мэдээллийн эх сурвалжийг задруулахыг хэнээс ч болов шаардах ёсгүй” гэсэн байдлаар хуульчилдаг. /Гүржийн “Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль”, Мексик, Францын “Эрүүгийн хууль”, Индонез, Мозамбик, Туркийн “Хэвлэлийн хууль”/

НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙН ХАМГААЛАЛТЫН ТҮВШИН

◎ Үл хамааруулах нөхцлийг заасан хамгаалалт

Хязгаарлалт тавих, эх сурвалжийг нэрлэхийг шаардсан шийдвэрийг зөвхөн хуульд нарийвчлан томъёолж заасан үндэслэлээр зөвхөн ардчилсан нийгмийн ашиг сонирхлын үүднээс шүүхээс гаргахыг хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ эх сурвалжийг нэрлэхийг шаардсан шийдвэр гаргах эрхийг шүүх хязгаарлалтгүйгээр эдлэх нь бас ардчилсан засаглалыг хөгжүүлэх зорилгод нийцэхгүй. Шүүхийн эрх мэдлийг хатуу тогтоогоогүй тохиолдолд эх сурвалжаа нэрлэхгүй байх үндэслэлээ тайлбарлах дарамт сэтгүүлчдэд ирсээр байх болно.

◎ Бельги, Герман, Филиппин, Армени, Финляндад эх сурвалжийн нууцыг задруулахаас татгалзах эрхийг сэтгүүлчдэд олгосон байдаг боловч тухайн тохиолдлоос хамаарч тодорхой шалгуур, дэг журмын дагуу эх сурвалжийг задруулах шийдвэр гаргах шаардлагыг хуульд тусгайлан заасан байдаг ажээ.

НУУЦ ЭХ СУРВАЛЖАА ХАМГААЛАХЫГ БАТАЛГААЖУУЛААГҮЙН ҮР ДАГАВАР

◎ Эрх зүйн хамгаалалт байхгүй тохиолдолд сэтгүүлч эх сурвалжаа нэрлэх, эсвэл хуулийн хариуцлага хүлээх ийм хоёр замын аль нэгийг сонгодог. Хамгийн аюултай нь ийм тохиолдолд мэдээллийн эх сурвалжаа ашиглаж чадахгүй, улмаар нийгэмд үнэн бодитой мэдээлэл түгээж чадахгүйд хүрдэг.

Эх сурвалжаа ил болгохыг сэтгүүлч, ХМБ-аас шаардах нь авах ёстой мэдээллийг тэднээс хүчээр булаан авч байгаатай агаар нэгэн болно гэж үздэг.

Хамгаалалт үгүй бол олон нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар эх сурвалжууд хэвлэл мэдээлэлтэй хамтарч ажиллах явдал хаалттай болно. Ингэснээр хэвлэлийн олон түмний хоточ нохой байх үүрэг хязгаарлагдаж, үнэн зөв найдвартай мэдээллээр хангах ХМХ-ийн чадвар хомсдоно.

НУУЦ ЭХ СУРВАЛЖАА ХАМГААЛАХЫГ БАТАЛГААЖУУЛААГҮЙН ҮР ДАГАВАР

Эх сурвалжаа илчлэхийг хүчээр шаардах явдлын хамгийн ноцтой үр дагавар нь сэтгүүлчийн мэдээлэл олж авах чадварт нөлөөлөх явдал. Илчлэгдэхээсээ айсан зарим эх сурвалжууд сэтгүүлчтэй ярилцахаас татгалзана. Нөгөө хэсэг эх сурвалж нь сэтгүүлчийг хараат бусаар мэдээлэл цуглуулагч бус Засгийн газрын гар хөл бологч гэж хардана, сэтгүүлчид итгэл үзүүлэхээ болино.

НУУЦ ЭХ СУРВАЛЖАА ХАМГААЛАХЫГ БАТАЛГААЖУУЛААГҮЙН ҮР ДАГАВАР

- ◎ Эх сурвалжид хүчирхэг хамгаалалт байхгүй тохиолдолд сэтгүүлч цуглуулсан мэдээллээ задруулах шаардлагатай тулгарахгүйн тулд нийтлэхгүй байх, шүүхээс эх сурвалжаа нэрлэхийг шаардсан тохиолдолд мэдээллээ устгах зэрэг үйлдлүүд хийдэг.
- ◎ Эх сурвалжийн хамгаалалт үгүйлэгдсэнээс үүдэн гарах хамгийн ноцтой үр дагавар бол сэтгүүлчийн бие махбодод заналхийлэх явдал. Ийм тохиолдолд тэднийг эрх мэдэлтнүүдийн мэдээлэгч буюу тагнуул туршуул гэж хардах, эсвэл хожмын шүүх хуралд гэрч болно гэж үзээд ангуучлах явдал гарч болно.

СЭТГҮҮЛЧИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙГ ХАМГААЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ОРУУЛЖ БОЛОХУЙЦ ХУВИЛБАНУУД

Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах шалгуур үзүүлэлт, сэтгүүлчийн эрх:

Сэтгүүлчид болон редакцийн зөвлөлийн гишүүд нь дараахь 4 нөхцөл байдалд шүүхийн эрх бүхий албан тушаалтны шаардлагын дагуу мэдээллээ илчлэхээс татгалзах эрхтэй. /Бельги улсын “Сэтгүүлчийн эх сурвалжийг хамгаалах тухай”/

- Хэрэв эх сурвалжийн бодит, жинхэнэ, байдлыг илчилж болох мэдээлэл байвал
- Хэрэв тухайн мэдээллийн эх үүсвэр, мөн чанарыг илчилж болохоор мэдээлэл байвал
- Хэрэв видео хэлбэрээр харагдах бүтээл болон текстийн зохиогчийн жинхэнэ байдлыг нь илчилж болохоор мэдээлэл байвал
- Илчлэх явдал нь мэдээлэл болон бичиг баримтыг илрүүлж болохоор бол

СЭТГҮҮЛЧИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙГ ХАМГААЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ОРУУЛЖ БОЛОХУЙЦ ХУВИЛБАНУУД

Английн 1998 оны Дата /өгөгдөл мэдээллийг/ хамгаалах тухай актын 10 дугаар зүйл: Сурвалжлагчийн дуугүй байснаас үүдэн Үндэсний аюулгүй байдал, гэмт хэргийн илрүүлэлт, түүнэс урьдчилан сэргийлэх ажил шударга ёсны эрх ашигт аюул занал учруулахаас бусад тохиолдолд сэтгүүлчийг нууц мэдээллээ илчлэхийг албадах ёсгүй гэж заажээ.

Шүүх болон захиргааны эрх бүхий албан тушаалтны өмнө гэрчээр дуудагдсан Хэвлэгчид, хянагчид, сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг ажилтнууд нь мэдээллийн эх сурвалж, дэмжигч, зохиогч, тэдгээрийн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээ илрүүлэхтэй холбоотой асуултуудад хариулахаас татгалзах эрхтэй.

СЭТГҮҮЛЧИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙГ ХАМГААЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ОРУУЛЖ БОЛОХУЙЦ ХУВИЛБАНУУД

Дараах 4 шалгуурыг хангасан гэдгийг баталж чадахгүй бол эрхийг нь шүүх хүлээн зөвшөөрч болно гэж үздэг. Үүнд:

- Харилцаа холбоо нь илчлэхгүй байх талаархи итгэл дээр суурилагдсан байх ёстой
 - Энэхүү итгэлцэл нь талуудын хооронд өрнөж буй харилцаанд маш чухал ач холбогдолтой байх ёстой
 - Хоорондын харилцаа нь дэмжлэг үзүүлсэн харилцаа байх ёстой
 - Илчилснээс үүдэн харилцаанд нь бий болсон уршиг нь маргаанд хүргэж болох зүйлээс ч илүү байх ёстой
- Сэтгүүлчийн үйл ажиллагаа явуулж буй сэтгүүлч болон бусад хүмүүс сэтгүүлчээр ажиллаж байхдаа олж цуглуулсан мэдээлэл болон факттай нь холбоотой шүүх хуралд гэрчээр оролцохыг шаардаж болохгүй.
Эдгээр хүмүүст мэдээллийн эх сурвалжаа хэлэхээс татгалзах эрх бий.

СЭТГҮҮЛЧИЙН МЭДЭЭЛЛИЙН НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙГ ХАМГААЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ОРУУЛЖ БОЛОХУЙЦ ХУВИЛБАНУУД

- ◎ **Сэтгүүлчийн нууц эх сурвалжаа илчлэх эрхийг хязгаарлах үндэслэлүүд:**

Шүүхээс дараахь 3 онцгой тохиолдолд эх сурвалжаа илчлэхийг сэтгүүлчээс болон редакцийн зөвлөлөөс шаардаж болдог.

- ◎ Нэг буюу түүнээс дээш хүний бие махбодод ноцтой аюул учруулах гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл бол
- ◎ Шаардсан мэдээлэл нь тэдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой бол
- ◎ Шаардсан мэдээлэл нь өөр арга замаар олж авч чадахааргүй бол
- ◎ **Мэдээллийг илчлэх нь дараахь тохиолдолд хууль ёсны болдог. Үүнд:**
- ◎ Тухайн эх сурвалжаас зөвшөөрөл өгсөн
- ◎ Энэ зүйлийн дагуу олон нийтэд илүү ач холбогдолтой байх зорилгоор мэдээллээр хангасан бол
- ◎ Илчлэх нь зайлшгүй шаардлага, зорилгоор хийгдсэн бол
- ◎ Эрүү, иргэний хэрэг шүүх ажиллагааны зорилгоор илчилсэн бол
- ◎ Илчлэх нь нийтийн ашиг сонирхолд шаардлагатай бол зэрэг болно.

Эх сурвалжаа ил болгохыг сэтгүүлч,ХМБ-аас шаардах нь авах ёстой мэдээллийг тэднээс хүчээр булаан авч байгаатай агаар нэгэн болно гэж үздэг.

Хэвлэл мэдээллийн олон түмний хоточ нохой байх үүрэг хязгаарлагдаж, үнэн зөв найдвартай мэдээллээр хангах ХМХ-ийн чадвар хомсдоно.